

Тавин хоёрдугаар зүйл

ЭЭНГУЙ ЭД ХӨРӨНГЭ

Хэрэв өв залгамжлах эрхийг тодорхойлох Хэлэлцэн Тохирогч Этгээдийн хууль тогтоомжоор өвлүүлэх эд хөрөнгө өв залгамжлагчгүй улдсэн бол хөдлөх хөрөнгийг өв залгамжлуулагч нас барах уедээ харьяат нь байсан Хэлэлцэн Тохирогч Этгээдэд, ул хөдлөх хөрөнгийг тууний нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн өмчинд тус тус шилжуулнэ.

Тавин гуравдугаар зүйл

Өв залгамжлалын талаар дипломат
төлөөлөгчийн бтү консулын газ-вын
төлөөлөх эрх

Хэлэлцэн Тохирогч нэг Этгээдийн дипломат төлөөлөгчийг буюу консулын газар тусгай итгэмжлэлгүйгээр Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн шуух болон бусад байгууллагад өөрийн харьяатын өв залгамжлал туунтэй холбогдон маргааныг шийдвэрлэхэд хэрэв иргэд өөрсдөө эзгүй байх буюу өөр итгэмжлэх хун томилоогуй уед тэднийг төлөөлнө.

Өв хөрөнгийг шилжүүлэх

Тавин дөрөвдүгээр зүйл

1. Энэхуу Гэрээний 55-р зүйлийн 2 дахь ангийн "б"--д заасан урьдчилсан нөхцлийг биелуулэн уед хэрэв өвлүүлэх хөдлөх хөрөнгө Хэлэлцэн Тохирогч нэг Этгээдийн нутаг дэвсгэрт байвал уг хэргийг авч хэлэлцэхийн тулд өвлүүлэх ажиллагааг авч хэлэлцэх эрх бүхий байгууллагад эсхул дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт шилжуулнэ.

2. Энэ зүйлийн I дэх ангид зааснаар Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд өвлүүлэх хөдлөх хөрөнгийг шилжуулэхийн өмнө өвлүүлэх эрх олж авахтай холбогдуулан тэр эд хөрөнгөөс